



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Концессын тухай хуулийн 6.1.1, 10.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 53 дахь заалтын "Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх" гэсэн хэсгийн "Уралдаант шалгаруулалт явуулах" гэснийг "Шууд гэрээ байгуулах" гэж өөрчилсүгэй.

2. Концессын "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх "Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр зам төсөл"-ийн шууд гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Хөрөнгө оруулалтын газар (С.Жавхланбаатар) болон Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Аж үйлдвэрийн сайд

Д.ЭРДЭНЭБАТ